



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/826

Булган сум

### Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудтай уулзах уулзалтад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудтай уулзах уулзалтыг зохион байгуулсугай.

2. Уулзалт зохион байгуулахад шаардагдах хөрөнгө 1,455,500 (нэг сая дөрвөн зуун тавин таван мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ хэрэгжүүлэх зардлын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл, Ахмад настны хөгжил хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны  
2 дугаар сарын 31-ны/ний өдрийн  
А.1826 дугаар захирамжийн хавсралт

БУЛГАН СУМЫН БАЙНГЫН АСАРГААТАЙ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ХҮҮХЭДТЭЙ ӨРХӨД ЭРГЭЛТ ХИЙХЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ

д/д	Зардлын төрөл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Буудлын үнэ	3	130,000 160,000 160,000	450,000
2	Хоолны үнэ	11	54,864	603,500
3	Гарын бэлэгний үнэ	6	67,000	402,000
<b>Дүн</b>				<b>1,455,500</b>

--o0o--